

УЛС ХООРОНДЫН ХИЛ, ЗААГИЙН АСУУДЛААРХИ ОНОЛЫН БАРИМТЛАЛУУДЫН ТУХАЙ

Дэлхийн улс гүрнүүд үүсч бас, устаж үгүй болсон түүхийн үйл явцыг ажиглахад "амьдрах орчин"-ы төлөөх тэмцэл нь тэдгээрийн орших, эс оршихыг тодорхойлогч гол хүчин зүйл болсоор иржээ.

Ямар ч улс үндэстэн "амьдрах орчин"-той өөрөөр хэлбэл өөрийн гэсэн газар нутагтай байж түүнийгээ хадгалж хамгаалахын төлөө тэмцэж хүчирхэгжихээрээ бусдын илүү таатай газар нутгийг хүч түрэн эзэлж, сулрахаараа бусдад эзлэгдэн хөөгдөж, зарим нь уусч, устаж, тэдгээрийн хөрсөн дээр шинэ улс үндэстэн үүсч... гэх мэтээр ямагт өөр хоорондоо зөрчилдөн тэмцэж иржээ.

Ер нь дэлхийд хүний нийгэм байгуулагдсан цагаас өнөөг хүртэл "амьдрах орчин"-ны төлөө тэмцэлгүй нэг ч өдөр байгаагүй гэхэд хилсдэхгүй. Хүн төрөлхтөн соёлжин боловсрохын хэрээр улс үндэстнүүдийн "амьдрах орчин" болсон газар нутаг, түүний хил заагийг хэрхэн тогтоох нь илүү найдвартай, оновчтой бат бэх байх талаар орон орны эрдэмтэн, судлаачид янз бүрийн онолын үзэл баримтлалуудыг боловсруулж хэрэгжүүлэхийг оролдож ирсэн байна.

1990 оны ардчилсан хувьсгалаас өмнөх үед манай Монгол улс төдийгүй тухайн үеийн социалист системийн гэгдэж байсан орнууд бүхлээрээ улсын хилийн тухай Марксист-Ленинист сургаалыг шүтэж, хил заагийн асуудлыг тайлбарлах гэсэн онолын өөр урсгалуудыг харгис онол гэж өрөөсгөлөөр тайлбарлан сурталчилж байв.

Эл учраас улс хоорондын хил заагийн асуудлаар дэлхий нийтэд түгсэн онолын баримтлалуудыг бодит байдлаар нь судлах явдал танин мэдэхүйн чухал ач холбогдолтой юм..

Ялангуяа Монгол улсад ардчилсан төр засаг тогтож, шинэ үндсэн хууль батлагдаж, дэлхийн хөгжлийн нийтлэг жишигтэй хөл нийлүүлж, бусдаас хараат бус бие даасан төрийн бодлогоо явуулж буй шилжилтийн үед манай судлаач эрдэмтэд, хилчид Монгол улсынхаа "амьдрах орчин"-оо хайрлах, хадгалан хамгаалах, бэхжүүлэх найдвартай байлгахын тулд эдгээр нөлөө бүхий онолын үзэл баримтлал, урсгалуудыг судлаж, эерэг сөрөг талыг нь мэдэж, цаашдын бодлого үйл ажиллагаандаа харгалзан үзэх нь зүйтэй байна.

а. "Бодит хил"-ийн онол

Улс үндэстнүүдийн хил, зааг нь газар зүйн байршлын хувьд оршин тогтноход нэн тааламжтай байх бөгөөд байгалийн саад бэрхшээл, уулын нуруу, мөрөн гол, далай тэнгис, элсэн цөл гэх мэтээр тусгаарлагдсан байвал гаднаас гэнэт халдан довтолж чадахгүй учраас улс үндэстэн удаан хугацаанд оршин тогтнож, цэцэглэн хөгжиж чадна гэсэн үзэл баримтлалд үндэслэгдсэн хамгийн анх түрүүнд гарч ирсэн онол бол "бодит хилийн онол" юм.

"Бодит хил"-ийн онол нь нийгмийн хөгжлийн тодорхой үе шатуудад улс гүрнүүдийн амьдрал практикт хэрэгжиж байсныг нотлох баримтлалууд эртний Грек, Рим, Хятад, Монголын түүхийн судар бичгүүдэд тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Жишээлэхэд: Эртний Хятадын Сыма цяны "Шицзы" гэдэг зохиолын "Хүннүгийн бүлэгт Хүннү-Дунхугийн хооронд хүн нутагладаггүй мянган газар эзэнгүй нутаг буй, тэд түүний хажуугаар "Оуто" болон нутагладаг гэжээ. "Оуто"-г хятадын түүхчид "Хилийн харуул", "Харуулын цайз" хэмээн тайлбарласан байдаг. Үүнээс үзэхэд эрт үед Монголын их говийн хүн нутагладаггүй өмнөд хэсэг байгалийн бодит саад болж байжээ.

"Бодит хил"-ийн онолыг боол эзэмшлийн үеэс XX зуун хүртэл дэлхийн улсууд хил заагаа тогтоохдоо ямар нэг хэмжээгээр голчлон баримталж ирсэн бөгөөд энэ нь улс орны аюулгүй байдлыг хангахад байгалийн бодит тогтоц хаалт саадыг ашиглах гэсэнтэй нягт холбоотой байв.

Суурин соёл иргэншилт Хятад улс нь нүүдэлчин соёл иргэншилт Монгол улсын байнгын гэнэтийн халдлага довтолгооноос хамгаалахын тулд нутгийнхаа хойд захын уул нуруудыг дамнуулан олон зуун километр хана хэрэм "Их цагаан хэрэм" босгосон нь өнөөг хүртэл түүхийн гайхамшигт дурсгал болон хадгалагдан үлдсэн бөгөөд энэ нь эртний хятадын хаадууд аюулгүй байдлаа хангахыг хичнээн их анхаарч, ямар их хүч хөдөлмөр зарцуулж байсны тод жишээ төдийгүй байгалийн бодит тогтоц саадыг нүүдэлчдийн довтолгоог тогтоон барих чадвартай болгохын тулд дээр нь хана хэрэм босгож тусгаарлан аюулгүй байдлаа хангаж байсны хамгийн тод жишээ юм.

XVI зууны үед Томас Морын төсөөлөн бүтээсэн "Утоп" улс нь хагас арал дээр байрладаг бөгөөд яваандаа хиймэл сувгаар эх газраас тусгаарлагдан арал болж хувирдаг болон, XVII зууны үед Т.Кампанеллын бичсэн мөрөөдлийн "Нарны хот" ч гэсэн өндөр довцог дээр байрладаг нь хотын гадаад аюулгүй байдлыг хангахтай холбоотой юм.

"Бодит хил"-ийн онолыг идэвхитэй дэмжигчдийн нэг нь Сен Симон байв. /XVIII-XIX зуун/. Тэрээр улсын хөгжлийн нууц нь түүний хил хязгаарын халдашгүй дархан, сайтар тусгаарлагдсан байдалтай салшгүй холбоотой гэж үздэг байв. Эртний Грек, Итали, Их британи, Египетийн эдийн засаг илүү хурдацтай хөгжсөн шалтгааныг тэдгээрийн бусад улс орноос далай тэнгис, элсэн цөлөөр тусгаарлагдаж байсантай холбон тайлбарлаж, Европын улсуудын засгийн газарт хандаж нэгэнт тогтсон байгалийн бодит хилийг өөрчлөхгүй байх, "бодит хил"-гүй улсууд өөр хоорондын хил заагаа өөрчилж "Бодит хил дотроо орох" -ыг уриалж байв.

"Бодит хил"-ийн онолын агуулгад XIX зууны эхээр зарим өөрчлөлт орсон бөгөөд энэ нь 1815 онд болсон Венийн конгрессийн баримт бичигт тусгалаа олжээ. Энд Франц Италийн төлөөлөгчид илүү идэвхитэй оролцож энэ онолыг дэмжиж байсан байна.. Тэрхүү баримтлалыг үндэслэгчдийн нэг Францын философич, нийтлэлч, монарх Бокальд хэлэхдээ "байгалийн бодит хилээрээ тогтсон улс /Жишээлбэл Франц –Рейнээр/ бол бусдыг байлдан дагуулах сонирхолгүй байдаг учраас энэхүү онол нь улсуудын хил заагийг тогтооход хэрэглэж болох илүү ухаалаг онол гэж үзэж байв.

С.В.Ф.Гегелийн 1820 онд бичсэн "Эрх зүйн философи" номонд: "Саяхан болтол гол мөрнийг бодит хил гэж үзэж байсан нь үгүй болж гол мөрөн хүртэл далай тэнгис мэт хүмүүсийг хооронд нь холбож байна. Горацийн сургаалд "Ухаант бурхан дэлхийн газар нутгийг хүн суудаггүй далай тэнгисээр салган заагласан ..." гэсэн нь буруу ойлголт бөгөөд үүнийг гол мөрний сав газарт амьдардаг улс үндэстэн төдийгүй Грек, Иония ба Их Грек, Бретань ба Британи, Дани ба Норвеги, Швец, Финлянд, Лифлянд гэх мэтийн хоорондын харилцаа нотолж байна. Ялангуяа эрэг орчимд оршин суугчид улс орны төв хэсэгт оршин суугчид хоорондын ойр зуурын харилцаа холбоотой харьцуулахад энэ нь ойлгомжтой болж байна..." гэжээ.

Ер нь түүний таамаглал нь улс гүрнүүдийн бодит хил болгосон мөрөн гол, далай тэнгис гэх зэрэг бодит усан саадтай юуны түрүүнд холбоотой байсан юм.

Г. В. Ф. Гегель энэ зохиолдоо газар зүйн байгалийн хаалт саадуудыг бүхэлд нь авч үзээгүй ч байгалийн бодит хаалт саадууд нь өөрийн тусгаарлагч үүргээ гүйцэтгэж чадахаа больж байгаа төдийгүй тэдгээрт холбогчийн шинэ үүрэг ноогдож эхэлж байгааг анх түрүүнд олж харсан юм.

Энэ шинэ үүрэг нь юу вэ гэвэл гол мөрөн, далайн зам харилцааг ашиглан хөрш зэргэлдээх улс орнууд өөр хоорондоо нягт

уялдаа холбоо харилцаатай болж байгаа байдал юм.

XIX зууны үед "бодит хил"-ийн онол нь нийгмийн үйлдвэрлэх хүчний хөгжил, улсын хилийн халдашгүй дархан байх ойлголтыг өөрчлөхөд хүргэсэн бөгөөд энэ онолыг шүтэн баримтлах нь ихээхэн хор холбогдолтой болох нь улс төрийн амьдралын практикаар нотлогдсон юм. Жишээлэхэд Европын хэд хэдэн томоохон улс /Герман, Франц/ бусдын газар нутгийг хүч түрэн эзлэх гэсэн шунахай сэдлээ "бодит хил"-ийн онолоор халхавчилж өөрийн улсын бодит хилийн заагт хүрэх гэсэн зарчмын санааг дэвшүүлж хөрш зэргэлдээх олон улс орныг эзэлж дайн түрэмгийлэл хийж байсан байна.

Ф.Энгельс "По ба Рейн" гэсэн бүтээлдээ энэ зарчмын явуургүй болохыг нотолж "Хэрэв улсуудын хил зааг нь цэргийн ашиг сонирхлоор тодорхойлогдох юм бол эцэс төгсгөлгүй маргаан будлиан үргэлжилнэ. ...Түүгээрч барахгүй хил зааг хэзээ ч шударгаар эцэслэн тогтоогддоггүй, яагаад гэвэл ялагч нь ялагдсан талдаа хэзээд өөрийн ашигтай нөхцөлийг тулгадаг. Энэ нь шинэ дайн байлдааны уг сурвалж болдог байна" гэжээ.

Үүнээс үзэхэд дэлхийн газар нутаг улсуудад хуваагдсан орчин үеийн нөхцөлд "бодит хил"-ийн онолыг шууд хуулбарлан хил тогтоох гэж оролдох нь хилийн маргаан будлиан, дайн байлдаан үүсгэх сөрөг үр дагавартай нь тодорхой байна. "Бодит хил"-ийн онол нь улсуудын хил заагийг байгалийн бодит тогтоцоор тогтоох зарчмыг баримтлахыг тодорхойлсон нь нийгмийн хөгжлийн эхний шатанд зөв зүйтэй байсан боловч түүхийн хөгжлийн тодорхой үе шат /XIX зуун/-аас эхлээд үйлдвэрлэх хүчний хөгжилтэй холбоотойгоор энэхүү онолын үзэл баримтлал, улс хоорондын хил заагийг тогтоох үйл явц хоёр зөрчилдөж эхэлжээ. Иймд энэхүү онолын үзэл баримтлалыг улс төрийн үндэслэлтэй зөв шийдвэр гаргах, хилийн асуудлыг шийдвэрлэхэд гол баримтлал болгож болохгүй.

Гэхдээ орчин үед Монгол улсын хилийн талаархи асуудлуудыг шийдвэрлэхэд улсын хилийн шугам, заагийн зарим хэсгүүд нь байгалийн бодит тогтоцын дагуу тогтоогдсон үндэслэлийг батлах, хил заагийн асуудлаар байгуулсан гэрээ хэлцэлийн мөн чанарыг тодруулахад "бодит хил"-ийн онолыг хэрэглэхийг үгүйсгэхгүй.

6. "Үндэстний хил"-ийн онол түүний төрлүүд

"Үндэстний хил"-ийн онолын баримтлал нь дэлхийн улс хоорондын хил заагийн онолын үндэслэлийг бүрдүүлэх дараагийн шат болсон бөгөөд хилийн асуудалд хандах хандлагыг ихээхэн

өргөжүүлсэн юм.

"Үндэстний хил"-ийн онолоор улсуудын газар нутгийн хил заагийг тэдгээрийн байршилд нийцүүлж тогтоох нь зүйтэй гэж үздэг. Өөрөөр хэлбэл энэ онолоор улс үндэстэн бүрэлдэн тогтох үндсэн нөхцөл нь нь тэдгээрийн нутаг дэвсгэр, эдийн засгийн дотоод хамаарал, хэл яриа, ёс заншил, соёл, сэтгэл зүйн нийтлэг хэв шинж байдаг байна.

Доктор Гүнжийн Сүхбаатар Монголчуудын эртний өвөг болох Хүннү нарын нийгмийн байгууламж, эдийн засаг, оюуны соёлын онцлог, түүний хөгжил сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй, малын үүлдэр угсаа, угсаатны зүйн асуудлын цогцолбор судалгааг сүүлийн 20 гаруй жил хийж "Хүннү нар бол эртний монгол угсаатан мөн" гэдгийг тогтоожээ. Энэ нотолгоо генетикийн шинжлэх ухааны судалгаагаар батлагдсан юм.

Доктор Ж.Батсуурь "Монголчуудын генийн сангийн голомт Хүннү улсын нутаг дэвсгэр, түүний улс төрийн төвтэй яв цав давхцаж байгаа явдал өнөөгийн монголчуудын генийн сангийн голомт ямар ч байсан Төв Азид хамгийн түрүүн төр улсаа байгуулж гарч ирсэн Хүннү нараас өвлөн ирсэн болохыг тодорхой харуулж байна" гэжээ.

Эртний Хүннү улсын нутаг дэвсгэрийн хил нь өмнө зүгт хятадын цагаан хэрэм, хойд зүгт Байгал нуур, баруун зүгт Тэнгэр уул, зүүн зүгт Солонгос хүрдэг байсан бөгөөд Хүннүгээс хойшхи Монгол улсын нутаг дэвсгэрт оршин тогтнож байсан Сүмбэ, Их нирун, Түрэг, Уйгар, Хиргис улсуудын газар нутгийн хил заагийг судлаж үзэхэд хойд, өмнөд зүгтээ онцгой өөрчлөгддөггүй байсан бөгөөд харин баруун талаараа Эрчис мөрөн зүүн талаараа Хянганы нуруу гэх мэтээр өөрчлөгдөн ихсэж багасаж байсан байдаг.

Энэ бүхнээс үзэхэд өнөөгийн монгол улс бол өөрийн эртний уламжлалт "үндэстний хил" дотроо оршин тогтнож байна.

"Үндэстний хил"-ийн онол нь тухайн нутаг дэвсгэр дээр амьдрагч ард түмнүүдийн үндэстний нийтлэг хэв шинжийг голчлон харгалздаг байсан учраас дэлхийн ихэнхи улс үндэстэн бүрэлдэхэд ихээхэн нөлөөтэй байсан боловч цаашид энэхүү онолын баримтлалыг өрөөсгөлөөр тайлбарлах гуйвуулж хэрэглэх хандлага цөөнгүй гарсан юм.

Тухайлбал зарим судлаач онолчид улс орон түүний хил зааг бүрэлдэн тогтоход ард түмнийх нь эдийн засгийн нийтлэг холбоо чухал үүрэгтэй гэж хэт дөвийлгөж "эдийн засгийн хил" гэдэг ойлголтыг буй болгосон юм.

Өөр нэг хэсэг нь улс үндэстний хил заагийг бүрдүүлэхэд нэг

хэл яриатай байх нь хамгийн чухал гэж тооцож **"Хэл нэгтний хил"** гэдэг ойлголтыг буй болгов.

Гурав дахь хэсэг нь нийгмийн байгууламжийг өөр хооронд нь зааглахад улс үндэстнүүдийн соёл иргэншлийн онцлог, шашин шүтлэгийн ялгаа, үндэсний сэтгэл зүйн өвөрмөц онцлогуудыг тооцох ёстой гэж үзэж **"Соёл иргэншлийн хил"** гэдэг ойлголтыг гаргаж ирсэн юм.

"Үндэсний хил"-ийн онолын дээрхи төрлүүд нь нэг улс доторхи хүмүүсийн нийтлэг харилцааны аль нэг хэв шинжийг хэт дөвийлгөж авч үздэг байна.

Жишээлэхэд орчин үед нэлээд дэлгэрсэн "Эдийн засгийн хил"-ийн онол нь улсын хил заагийг төрөл бүрийн нутаг дэвсгэрийн эдийн засаг, худалдааны хэлхээ холбооны нийтлэг байдлыг харгалзан тогтоох ёстой гэж үздэг. Ер нь эдийн засгийн хүчин зүйл улс үндэстний оршин тогтнохын үндэс суурь болж улсын хил зааг, хил орчмын дэглэмийг тогтооход гол нөлөө үзүүлдэг нь маргаангүй юм. Түүгээрч барахгүй орчин үеийн олон улсын амьдралын туршлага дээрхи онолын зөв болохыг зарим талаар баталсан юм.

1993 оны 1 сарын 1-ээс эхлээд 350 сая Европчууд Белги, Франц, Итали, Люксембург, Нидерланд, Герман, Их Британи, Ирланд, Дани, Грек, Испани, Португали зэрэг орны иргэд дотоодын хил зааггүй, нэг нэгдмэл газар нутагтай, чөлөөт эдийн засгийн орон зайд амьдрах болсон бөгөөд цаашид энэхүү Европын холбоонд Австри, Швед, Финлянд, Швейцари зэрэг орнууд нэгдэн нэг эдийн засаг, нэгдсэн газар нутаг, нэгдсэн мөнгөн тэмдэгттэй /Евровалют/ дэлхийд нөлөө бүхий улсуудын холбоог бүрдүүлж байна.

Гэхдээ энэ жишээг иш татахдаа бид дээрхи холбоо байгуулахад нөлөөлсөн дараахь хэдэн хүчин зүйлийг дурдахгүй байж болохгүй.

- Эдгээр улсуудын хоорондын хил заагийг нээх асууудал нь тус холбооны бүрэлдэхүүнд багтах улсуудын хамтран байгуулсан Европарламент, Европын шүүх, Европын хамтын нийгэмлэгийн комисс гэх мэтийн байгууллагуудын улс үндэстэн бүрийн хөгжлийн төвшин, нийгмийн байгууламж, улс төрийн зорилго, хөтөлбөр, нийгмийн сэтгэл зүйг судалж тохируулах, нэгдсэн нэг зах зээл, эдийн засгийн системтэй болох талаар 35 жилийн туршид хамтран хийсэн судалгаа, туршилтын ажлын үр дүнд шийдвэрлэгдсэн юм.

- Эдгээр улсуудын нэгдэлт нь түүхийн хөгжлийн уламжлалаараа өөр хоорондоо төстэй Европын улсуудын хязгаарлагдмал орон зайд байгуулагдсан байна.

- Европын холбооны улсууд нь улс төр-нийгмийн байгууламжийн хувьд адил төстэй ардчилал, олон ургальч үзэл, нийгмийн дэвшлийн үзэл санааг бүрэн дэмждэг нийтлэг хэв шинжтэй байв.

-Дэлхийн хоёр дайнаас улс төр, нийгэм эдийн засаг, оюун санааны томоохон сургамж авсан баруун европын улсуудын дайны дараахь бүх түүхэн үйл явц нь Европын холбоо байгуулахад чиглэж байсан юм.

Энэ үе нь анги үндэстнийг шүтсэн хуучин "үндсэрхэг" үзэл баримтлал хүний эрхийг эрхэмлэсэн шинэ "Европжих" үзэл баримтлал хоёрын хоорондын тэмцлийн үе байсан бөгөөд шинэ үзэл санаа хуучнаа дийлснээр хил зааггүй Европыг байгуулах болсон юм.

Нэгдсэн Европ байгуулагдсан нь "Эдийн засгийн хил"-ийн онол цэврээр хэрэгжлээ гэсэн үг биш бөгөөд яагаад гэвэл, түүнийг байгуулахад эдийн засаг, нутаг дэвсгэр, нийгэм улс төр, үндэстэн, соёл иргэншил, сэтгэл зүйн олон хүчин зүйлүүд нөлөөлсөн байна.

XIX-XX зууны үед "Үндэсний хил"-ийн онолд "Үндэсний соёл иргэншил"-ийн шинэ урсгал үүсч буй болов. Үүнийг баримтлагчид нь нийгмийн орон зайн газар нутгийн хил, заагийн шалгуур нь соёлын өв, үндэсний онцлог, уламжлал, шашин шүтлэг гэж үзэж байв.

Энэхүү санаа нь оросын нэрт сэтгэгч М. А. Бакунины XIX зууны 50-иад онд бичсэн Европын Нэгдсэн Холбоо байгуулах тухай төсөлд нилээд тодорхой тусгагдсан байдаг.

Энэхүү М. А. Бакунины төслийн гол санаа нь олон үндэстнээс бүрдсэн Орос, Габсбург, Османы эзэнт гүрнүүдийг нурааж тэдгээрийн нуранги суурин дээр үндэс язгуурын төстэй байдлаар нэгдсэн чөлөөт улсууд буй болж хөгжихөд оршиж байсан юм.

М. А. Бакунин улс хоорондын хил заагийг улс төр, цэрэг стратегийн ашиг сонирхол, газар зүйн онцлогоор тогтоох зарчмыг үндсэндээ бүрэн эсэргүүцэж тэдгээрийг тогтоох үндсэн шалгуур нь **"Ард түмний санаа зориг"** гэж үзэж байв. Түүний санаагаар бол Европын Нэгдсэн Холбоо нь бүрэлдэхүүндээ орсон улсуудын бие даасан байдлыг баталгаажуулж нэгдэн нийлэх болон салан тусгаарлах эрхээр бүрэн хангах ёстой ажээ.

М. А. Бакунин Славян үндэстэн ард түмний түүх болон тухайн үеийн бодит байдлын баримт материалд тулгуурлан славян ард түмний давуу тал, нэгдэхийн чухлыг нотлохыг хичээсэн юм. Энэхүү үзэл санаа нь XIX зууны Орос, Болгар, Унгар, Германд ихээхэн дэлгэрсэн "Панславизм"-ын үзэл баримтлалд тусгалаа олж XIX зууны сүүлийн хагаст Европ тивд болсон үйл явдлуудад /1863-1864 оны

Польшийн бослого, 1877-1878 оны Болгарыг чөлөөлөхийн төлөөх Орос Туркийн дайн/ энэ онолын баримтлал нөлөөлсөн гэдгийг ямар ч судлаач эсэргүүцээгүй билээ.

Гэхдээ Марксист-Ленинист сургаалыг баримтлагчид энэхүү онолын баримтлалд хэт ангич байр сууринаас хандсан байна. Тухайлбал Ф. Энгельс "Панславизмийн үндсэн чиглэл нь Австрийн хувьсгалын элементүүдийн эсрэг чиглэгдсэн учраас харгис шинж чанартай" гэж байв.

Энэ үзэл санааг В. И. Ленин "Социалист хувьсгал ба үндэстнүүдийн тусгаар тогтнох эрх" зохиолдоо цааш улам дэлгэрүүлж Европын марксизмын үзэл санаа ялан дийлж, хувьсгалт хөдөлгөөн хүчээ авахын хэрээр "Панславизм"-ийн онолын баримтлалыг сонирхох явдал улам багасч октябрийн хувьсгал ялснаар "Панславизм" өөрийгөө бүрэн үгүйсгэсэн юм" гэжээ.

Зөвлөлт Холбоот Улс задарсны дараа тодорхой хугацаа өнгөрөхөд түүнд харьяалагддаг асан славян үндэстэн ард түмнүүд /Орос, Украин, Беларусь/ болон түрк хэлтэн улсууд /Түрк, Азербайжан, Киргизистан, Туркменстан, Узбекистан, Казакстан/ өөр хоорондоо ойртон нягтрах үйл явц ажиглагдаж байна. Үүнээс үзэхэд "Панславизм" болон "Үндэстний соёл"-ын үзэл баримтлалын бусад урсгал нь нийгмийн практикт хэрэглэгдэж байгаа учраас орчин үед тэдгээрийг үеэ өнгөрөөсөн гэж үзэх нь учир дутагдалтай юм.

"Үндэсний хил"-ийн онол нь Германд пангерманизм, АНУ-д Панамериканизм, Изральд Сионизм, дундад азийн орнуудад "Исламжих" гэх мэтийн үндсэрхэг болон шашны үзэл дээр суурилж туйлширсан номлолуудыг буй болоход гол суурь дэвсгэр болсон юм.

Пангерманизм гэдэг бол дэлхийд ноёлохыг санаархсан Германы империалистуудын харгис түрэмгий бодлогыг тусгасан улс төрийн номлол юм. Энэ номлол нь XIX зууны эцсээр Австро-Унгарт немцийн үндэстний намын эгнээнд буй болжээ. Пангерманизмын үзлийг номлон дэлгэрүүлэгч нь 1891 онд байгуулагдсан Пангерманы холбоо бөгөөд тэр нь өөрийн бүрэлдэхүүнд Германы хөрөнгөтний аль түрэмгий хэсэг, юнкерийнхнийг багтаан авч 1989 оныг хүртэл тогтож байв. Пангерманизмын онолчид байлдан эзлэх аян хийх суурь нь Германаар толгойлуулсан "Дундаж Европ" байх ёстой гэж үзэж байлаа. Пангерманизмын чухал бүрэлдэхүүн хэсэг нь "Дранг Нах Остен" гэгч номлол юм. Энэ номлолоор бол Балти орчмын нутаг Польш, Украин, Беларусыг цэргийн хүчээр Германд нэгтгэж эзэлсэн газар нутгийг немецчлэх ёстой байв.

Пангерманизм нь германы фашизмын урьдач үзэл суртал

болж Пангерманы холбооны ихэнхи гишүүд нацист намд элсэн орсон билээ.

Панамериканизм. Энэ номлолыг баримтлагчид нь америк тивийн бүх орон улс төр, газар зүй, оюуны нэгдэлтэй байх ёстой гэж нотолдог.

Энэ онолд нийцүүлэн АНУ "Америкчуудын төлөө Америк гэдэг номлолыг тунхаглажээ. Панамериканизмын үзэл нь 1889 онд байгуулагдсан Панамерикийн холбоо гэгчид биелэлээ олсон бөгөөд 1948 онд нэрээ өөрчлөн "Америкийн улсуудын холбоо" гэж нэрлэгдэх болжээ.

Панамериканизмын онол нь дэлхий дахинд АНУ-ын нөлөөлөл хүчтэй болохын хэрээр улам бүр өргөн дэлгэрэх хандлагатай болж байна. Энэ онолын мөн чанар нь америк маягийн амьдралын хэв маягийг хэт дөвийлгөн магтаж, АНУ-ын үндэсний ашиг сонирхлыг улс хоорондын асуудлыг шийдэхдээ урьтал болгодог байна.

Олон улсын харилцаанд улс төрийн шинэ сэтгэлгээ зонхилох болсон өнөө үед АНУ-ын хөрш зргэлдээх болон алслагдсан улсуудын эсрэг /Гренада, Куба, Ирак, Югослав/ тэдгээрийг өөрийн ашиг сонирхолдоо захируулахын тулд зэвсэг, хүч хэрэглэн номхтгож байгаагаас үзэхэд энэхүү онолын мөн чанарыг цаашид улам нарийвчлан судлах нь чухал юм.

Сионизмыг баримтлагчид нь нэг хэлээр ярьдаг бүх хүмүүсийг нэг улсад нэгтгэх нь зүйтэй гэж үздэг. Фашист Герман улс түмнийг нэгтгэх энэ зарчмыг шалтаг болгон тухайн үедээ Австри Чехийн Судец мужийг булаан авч байсан түүхтэй. Эдүгээ Изралийн сионистууд "бүх мах цусны барилдлагатай ах дүү нараа нэг ширээнд суулгах", "хүслэн болсон нутаг оронд нь цуглуулах" нэрийдлээр Арабын хойг дахь Изралийн газар нутгийг өргөтгөж "Аугаа их Еврейн улс гүрэн" байгуулах зорилт тавьж хөрш улсуудын хооронд тогтоосон хил заагийг өөрчлөхийг санаархацгаадаг. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд сүүлийн 20-30 жил өөрийн ойрын хөрш палестины газар нутгийг эзлэн түрэмгийлээд зогсоогүй Египет, Сирийн нутаг дэвсгэрт ч өнгөлзсөн билээ.

Сүүлийн жилүүдэд дундад азийн лалын шашин шүтдэг орнуудад "Исламжих" үйл явц нилээд газар аваад байна.

1972 онд Афганы лалын намыг үндэслэгчдийн нэг Хабиб Рахман "Бидэнд /мусульмануудад/ хил хязгаар гэж байхгүй. Бүх дэлхийн мусульманчууд нэг туг, нэг сүлдэн дор амьдарцгаах цаг ирнэ" гэж мэдэгдэж байсан.

Лалын шашин шүтдэг эдгээр орон өөр хоорондоо ойр дотно

харилцаатай болж байгаа боловч үүндээ үндэслээд нэг засаглал, нэг газар нутагтай болсон юм үгүй байна.

Хуучин ЗХУ-ын суурин дээр шинээр үүсч буй болж байгаа улсуудын хооронд /Орос, Украин, Грузин, Хойд Осетин, Азербайжан, Армен г.м/ газар нутгийн маргаан тасрахгүй байна. Эдгээр улсуудын хоорондох хил заагийг тогтоохдоо "үндэсний хил"-ийн онолыг баримтлах, үндэсний онцлог, ашиг сонирхолд нийцүүлэн хил заагийг өөрчлөн тогтоох гэсэн оролдлого газар авч байгаа нь Зөвлөлт Холбоот Улсын задралыг цаашид гүнзгийрүүлэх маш ноцтой юм.

Энэ асуудлаар тухайн үедээ хил заагийн асуудлыг нэг мөр шийдсэн. Тухайлбал XX зууны 60-70-аад онд Африкийн улсуудын газар нутгийг заагласан туршлагыг судлах нь асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн хувь нэмэр болж болох юм.

Африкийн колонийн задралын дараахь газар нутгийн хуваарилалтаар Африкийн улсуудын хил заагласан шугамын 44 хувь нь уртраг, өргөргийн дагуу, 30 хувь нь шулуун болон нум хэлбэрийн шугамаар, зөвхөн 26 хувь нь байгалийн тогтоцоор дайрч өнгөрсөн байна. Энэ нь тэдгээрт амьдарч байгаа үндэстэн ястаны оршин суух газар зүйн байршилтай тэр бүр тохироогүй юм.

Африкийн улсуудын хил заагийг хүчээр өөрчлөхийн эсрэг арга хэмжээ нь XX зууны дунд үед колончлолоос чөлөөлөх явцад тогтсон **"тусгаар тогтнолын залгамж чанарын зарчим"** юм. Үүний мөн чанар нь шинээр буй болсон хараат бус улсууд нь колони эзэмшигч орнуудаас газар нутаг, хил заагаа залгамж чанартай тэр хэвээр нь хүлээн авах бөгөөд түүнийг хүч хэрэглэн өөрчлөхөөс татгалзах явдал юм.

Дээр дурдснааас үзэхэд үндэсний хилийн онолыг улс төрийн практикт хэрэглэхдээ зөвхөн нэг талыг барих явдал учир дутагдалтай гэдгийг ямагт санаж байх хэрэгтэй.

Улс орнуудын газар нутаг бүрэлдэн тогтож, бэхжихийн гол тулгуур үндэс нь эдийн засгийн амьдрал нийгэм улс төрийн байгууламж нэгдмэл байх, нэг газар нутаг, хэл яриа, соёлтой байх хийгээд үндэстнүүд нь бие биеэ зөв ойлгодог түүхэн уламжлалт холбоо юм.

Энэ бүхний үндсийн үндэс нь эдийн засгийн амьдралын нийтлэг хэв шинж ажээ.

в.Марксист - Ленинист онол

Улс хоорондын хил заагийн асуудлаархи Марксист - Ленинист

онолын баримтлал нь улсуудын газар нутаг, хил хязгаарын талаархи үзэл бодлын онцгой систем бөгөөд энэ бүхэн нь К. Маркс, Ф. Энгельс, В. И. Ленин нарын хэд хэдэн бүтээлд бичигдэж, судлаачдын энэхүү салбарт хийгдсэн нилээдгүй судалгаагаар баяжигдсан байдаг.

Марксист – Ленинист сургаалыг үндэслэгчдийн гавьяа нь "Хил" гэдэг ухагдахууны философи сэтгэлгээний үндэслэлийг гаргаж, түүний байгаль нийгэм, сэтгэхүйд нөлөөлөх онцлог байдлыг тодорхойлж чадсан явдал юм.

Ф.Энгельс "Гэр бүл хувийн өмч, төрт улс үүссэн түүх" номондоо нийгмийн орчинд газар нутгийн зааг ялгаа буй болсон нь төрт улс байгуулагдахын гол нөхцөл болсон гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Түүгээр ч барахгүй энэ зааглалт нь тодорхой тогтоосон хилийн шугамаар бус отог омгийн хоорондох харьяалалгүй бүсээр / хилийн орон зай/ тогтоогдож байсан гэдгийг Ф.Энгельс тодорхойлсон юм.

Марксизм-Ленинизмын үндсийг тавигчдын хилийн тухай онолын хөгжилд оруулсан хувь нэмэр нь улсын амьдралд газар нутгийн ач холбогдлыг задлан шинжилж улс үүсэх үйл явцад газар нутгийн хамаарлын нөлөөллийг тогтоосон явдал юм.

Ф.Энгельс цусан төрлийн холбооны хувьсал нь улс үүсэх үед газар нутгийн холбоо болон өргөжсөн болон эдгээр холбоо нь нийгэм эдийн засгийн төрөл бүрийн байгууламжтай улс орнуудад хэрхэн өөрчлөгдөх диалектикийг дэлгэрэнгүй судалсан юм.

Мөн К. Маркс, Ф. Энгельс, В. И. Ленин нар улсын хилийг шударга ардчилсан зарчим дээр үндэслэн тогтоохын төлөө байсныг тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ "ардчилсан" зарчим нь энэхүү онолын баримтлалд өвөрмөц шинж чанарыг агуулж байв.

Марксист – Ленинист онолоор бол улсын хилийг ардчилсан зарчмаар тогтоохыг ангич байр сууринаас шийдвэрлэж пролетари ангийн ашиг сонирхолд нийцүүлэн тогтоосон хил нь хамгийн шударга ардчилсан байна гэж үзэж байв.

Марксист – Ленинист онолын баримтлалын хүрээнд улсын хил заагийн асуудалд ангич байр сууринаас хандсан явдал нь онол-арга зүйн болон улс төр- нийгмийн бодлогын хүрээнд том алдаа болсон юм.

В. И. Лениний үе залгамжлагчид нь түүний газар нутгийн хил заагийн асуудалд ангич байр сууринаас хандахдаа тэдгээрийг үндэсний асуудлаас хэт дээгүүр дөвийлгөж туйлширч байгаагүйг үл харгалзан хил заагийн асуудалд зөвхөн ангич байр сууринаас хандаж ирсэн юм. В. И. Лениний энэ талаар үзэл бодлоо илэрхийлсэн

бүтээлүүдэд энэ хандлага тодорхой тусгагдсан байдаг. Залуу Зөвлөлт улс байгуулагдсаны дараахь хүнд бэрх жилүүдэд В. И. Ленин орон бүхний ажилчин ангийн нэгдэл нягтралыг чухалчилж байсан нь тодорхой байдгийн зэрэгцээ зарим бүтээлдээ өөр санаануудыг ч үзэглэн үлдээсэн байдаг.

Хүн төрөлхтөн коммунист өөрөө удирдах ёсны нийгэмд шилжин орох явцад үндэстнүүд хоорондоо ойртож уусах замаар улсын хил зааг нь аяндаа устаж үгүй болно гэж Марксизм-Ленинизм сургадаг. Ингэхдээ Марксизм - Ленинизмийн үндсийг тавигчид нь энэ үйл явц туйлын хэцүү бөгөөд урт удаан хугацаанд явагдана гэдгийг ойлгож байсан учраас ирээдүйн улсын хилийн талаархи асуудлыг коммунист нийгмийн ирээдүйг төсөөлдөг шигээ туйлын ерөнхий байхаар тайлбарласан байдаг. Өөрөөр хэлбэл энэ номлолын хүрээнд улсуудын хил зааг нь бүрэн устаж үгүй болох тухай асуудал нь агуулгын хувьд тодорхойгүй, ирээдүйн дэлхийн улсуудын хил заагт гарах өөрчлөлтийн мөн чанарыг бүрэн тусгаж чадаагүй байдаг байна.

г. "Хилийн газар зүйг өөрчлөх" онол

Энэ онолын гол үзэл санаа нь одооны улс орнуудын хилийн шугамын явалт, газар нутгийн хэмжээ байршил нь газар зүйн хүчин зүйлүүд /байгалийн нөөц баялаг, тогтоц, цаг уур г.м/-ээс хамааралтайгаар тогтоогдсон. Дэлхийн хүн ам геометрийн прогрессоор өсч байхад тэдгээрийн хэрэгцээг хангах нөөц баялгийн үйлдвэрлэл арифметикийн прогрессоор өсч байна. Иймд хүн ам ихтэй улсууд хүн амынхаа өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хөрш орнуудынхаа газар нутгаас авч өргөжүүлэх бодит шаардлага зайлшгүй урган гарч урьд тогтоогдсон хилийн газар зүйг өөрчлөхөд хүргэнэ гэж үздэг байна.

Хилийн газар зүйг өөрчлөх онолын үндсийг тавигч нь Ф. Ратцель болон энэ чиглэлийн бусад судлаачдын онолын үзэл баримтлалуудаас үзэхэд тэдгээрийг номлогчид нь улс орон томорч хөгжих нь зөвхөн хүч хэрэглэх замаар газар нутгаа тэлж хэрэгжих боломжтой гэж голдуу өрөөсгөлөөр тайлбарлацгаадаг байна. Дэлхийн газар нутаг нь улс гүрнүүдэд хуваагдаж бүрэн дууссан, колонийн систем задран унаж сүүлчийн колони орон Макао 1999 онд Португалийн хараат байдлаас гарч эх газрын Хятадын мэдэлд эргэж орсон шинэ нөхцөлд нэгэнт тогтсон газар зүйн хуваарилалтыг өөрчлөх гэсэн иймэрхүү онолын үзэл баримтлал байдаг нь ихээхэн сэтгэл түгшээсэн харгис мөн чанартай боловч нэгэнт олон нийтийн дунд

яригдаж судлагдаж байгаа нь бодит үнэн тул түүний мөн чхаар агуулгыг анхааралтай нягтлан судлах шаардлагатай юм.

Зарчмын хувьд улс үндэстнүүд хөгжихийн тулд сайн дураар нэгдэн нийлж болох боловч энэхүү онолыг хэрэгжүүлэх онол практикт ямагт хүч хэрэглэх замыг урьтал болгодог байна. Тухайлбал Германы фашистууд "дээд" арьстанд Урал хүртэл үргэлжлэх амьдрах орон зай хэрэгтэй. Амьдрах энэхүү орон зайгаа байлдан олох хэрэгтэй гэж номлоцгоож хүн төрөлхтөний түүхэнд хамгийн их цус урсгасан дэлхийн 2-р дайны галыг шатаасан юм.

Дэлхийн улс гүрнүүд дэлхийн газар зүйг өөрчлөх, хүчээр дахин хуваарилах нь нийтийг хамарсан томоохон аюул гамшиг учруулж болох /олон хүн ам үрэгдэнэ, эдийн засгийн их гарз хохирол амсана, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдана г.м/ сөрөг үр дагавартайг хүлээн зөвшөөрч, хил зааг, газар нутгийн маргаантай асуудлыг хүчээр бус тайван замаар соёлтой арга хэлбэрээр шийдэхийг эрхэмлэх болж байна.

д. "Олон улсын хил"-ийн онол

"Олон улсын хил"-ийн онол нь дэлхийн хоёрдугаар дайнаас хойш үүсч дэлгэрсэн.

Энэхүү онолын баримтлал нь улсуудын ойртон нягтарч байгаа бодит процесс нь улсуудын бие даасан байдал, хил заагийн үүрэг ролийг эрс бууруулж байна. Энэ үйл явц нь улсуудыг зааглаж тусгаарласан шугамыг "арилгаж" эцсийн дүндээ "олон улсын хил"-тэй байх, бусад нь манай одооны орон нутгийн засаг захиргааны зааг хязгаар шиг байх нь зүйтэй гэж үздэг.

Энэ хил нь дэлхийн хоёр өөр системийн ашиг сонирхлын уулзвараар тогтоогдох юм гэж анхандаа үзэж байв.

Энэ нь дэлхийн капиталист-социалист системийн урт хугацаанд сөргөлдөх үйл явцад анх буй болж "Хүйтэн дайн"-ы үед АНУ, ЗХУ хоёрын гадаад бодлого нь хамсаатнаа олж өөрийн талд элсүүлэх, өөр лагерийнхнаас зохиомол "Хилийн орон зай"-г үүсгэх замаар тэдгээрийг салган тусгаарлахад чиглэгдэж байв. Олон улсын хилийн онолын нэг хувилбар болох "Хараат байдлын тухай баримтлал энэ үед нилээд газар авч сөргөлдөгч лагерийн орнуудыг энэ байдлаар нь тодорхойлж харьцдаг байв шүү дээ.

Тухайлбал ЗХУ-ын зүгээс АНУ нь НАТО, АНЗЮС, СЕНТО-ийн орнуудыг хараат байдалд байлгаж байна гэж, АНУ-ын талаас Варшавын гэрээ, ЭЗХТЗ-ийн орнуудыг ЗХУ-ын хараат гэж үзэж байсан

нь бодит байдлаас хол зөрүүгүй байсан юм.

Гэхдээ цаг хугацаа өнгөрөх бүр олон улсын харилцаа зөөлөрч нийгмийн хөгжлийн бодит нөлөөгөөр энэ үзэл санаа өөрчлөгдөж, улсуудын хоорондын төрөл бүрийн харилцаа холбоо улам бүр зузаарч байна.

Үүний зэрэгцээ үйлдвэрлэлийг түүхий эд энергээр хангах, байгаль орчныг бохирдохоос сэргийлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, хөгжиж байгаа улсуудыг нийгэм эдийн засгийн хоцрогдлоос ангижруулах, сансар огторгуй, далайн гүнийг эзэмших, дэлхийн халуун цөмийн дайнаас урьдчилан сэргийлэх зэрэг дэлхий нийтийг хамарсан олон томоохон асуудлуудыг шийдвэрлэх явдал хүн төрөлхтөний өмнө тулгарсан юм.

"Олон улсын хил"-ийн онолын хүрээнд хэд хэдэн бүлэг улсуудыг нэгтгэсэн дэлхийн улсыг байгуулан "дэлхийн дэг журам"-ыг тогтоох үзэл санаа төрсөн юм.

Одоогоор дэлхийн улсуудын эдийн засгийн хөгжлийн түвшин, нийгэм улс төрийн байгууламжийн тогтолцооны зааг ялгаа, үндэсний бие даасан байдал, тусгаар тогтнол, хил заагийн тогтоцыг харгалзахгүйгээр дэлхийн нэгдсэн улс байгуулах ямарч боломжгүй нь тодорхой байгаа бөгөөд нэгдсэн улс байгуулах нь бодит зүйл биш юм. Магадгүй алс хэтийн хэрэг байж практикт хэрэгжихдээ бүсчилсэн байдлаар /Европын холбоо, Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг, Европын Карпатын бүс гэх. мэт/ явагдах шинж төлөв илүү ажиглагдаж байна.

Сүүлийн жилүүдэд "олон улсын хил"-ийн онолын хүрээнд тусгаар тогтнолын үүрэг хариуцлага"-ын тухай үзэл баримтлал онцгой байр суурь эзлэх болов. Энэ нь нийтийг хамарсан томоохон асуудлыг нэг улсын хүрээнд шийдвэрлэж болохгүйтэй холбоотой юм.

Үүний мөн чанар нь улс нь гүйцэтгэх үүргийнхээ тодорхой хэсэг зарим эрх мэдлийг олон улсын байгууллагаар даалгах явдал юм. Ийм байгууллагууд одоо олноор буй болж нийт хүн төрөлхтөний өмнө зогсож байгаа зорилтыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээний туршлагатай болжээ.

Нэгдсэн Үндэсний байгууллага /НҮБ/, Олон улсын цөмийн энергийн агентлаг/МАГАТЭ/, Олон улсын экологийн нийгэмлэг /Гринпис/, Олон улсын валютын фонд /ОУВФ/, Олон улсын өөрчлөн байгуулалт хөгжлийн банк /ОУӨХБ/, Азийн хөгжлийн банк /АХБ/, НҮБ-ийн боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан байгууллага /ЮНЕСКО/, НҮБ-ын үйлдвэрлэлийн хөгжил хариуцсан байгууллага /ЮНИДО/, НҮБ-ийн худалдаа хөгжлийн бага хурал /

ЮНКТАД/ гэх мэт.

"Олон улсын хил"-ийн онолын нэг төрөл нь "Хүн төрөлхтөний нийтлэг өв"-ийн үзэл баримтлал юм.

Хүн төрөлхтөний нийтлэг өвд дэлхийн аль ч улсад хамааралгүй байгалийн баялгийг ойлгодог. Тухайлбал дэлхийн далайн гүнд буй минералийн нөөц юм.

НҮБ-ийн далайн эрхийн асуудлаар болсон III бага хурал, дэлхийн нөөц баялаг хомсдож байгаа боловч дэлхийн далай тэнгисийн ёроолд хүн төрөлхтөн ашиглаагүй асар их нөөц баялаг байгааг цохон тэмдэглэж, дотоодын болон газар нутгийн усан хилээс ангид байгаа дэлхийн далайн нөөц нь хүн төрөлхтөний нийтлэг өв мөн. Үүнийг зөвхөн дэлхийн зориулалтаар шударгаар хувиарлан ашиглах ёстой гэж цохон тэмдэглэсэн юм.

Энэ бүхнээс үзэхэд "Олон улсын хил"-ийн онол нь орчин үеийн улсуудын улам бүр ойртон нягтарч өргөжиж байгаа олон талт харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлж зарим улсуудын дэлхийн бодлогод нөлөөлөхүйц тусгаар улс болох гэсэн эрмэлзлэлийг тодорхой хэмжээгээр хязгаарлах үйл явцын бодит тусгал болж байгаа юм.

Энэ бүх онолын ойлголтууд нь хил судлалын арга зүйн суурийг өргөжүүлж, Монгол улсын оршин тогтнохуйн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зөвхөн өөрийн орны дотоод хууль тогтоомжинд төдийгүй, олон улсын хууль тогтоомж, олон улсын эрх бүхий байгууллагуудын шийдвэр, нийгмийн амьдралын төрөл бүрийн салбар дахь хөрш улсуудын хамтын ажиллагааны өргөжилт бэхжилтэд нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх нь чухал болсныг нотолж байна.

Орчин үеийн улсуудын харилцаа үзэл сурталчлагдах явдлаас салж байгаа шинэ нөхцөл нь улсын хилийн нийгэм-улс төрийн мөн чанар агуулгыг ихээхэн өөрөөр ойлгож тайлбарлахад хүргэж байна.

Дэлхийн нийгэм улс төрийн эсрэг тэсрэг хоёр системийн үед хил заагийн асуудлаар явуулж байсан "Төмөр хөшиг"-ний бодлого үндсэндээ үгүй болж хил дээр хатуу сэргэлдсэн байр сууринаас бус хүний үйл ажиллагааг хууль зүйн дагуу уян хатан зохицуулах арга барилыг голчлох болж байна.

Гэхдээ үзэл баримтлалын өөрчлөлт нь улсын хилийн улс төрийн мөн чанарыг үгүйсгэж байгаа хэрэг биш юм.

Ямарч үед улсын хил зааг нь тухайн улсынхаа төрийн засаглалын зааг хязгаар байсаар байсан, байх ч учиртай тул харьяалагдах улсынхаа нийгэм-улс төрийн мөн чанарыг хадгалж байдаг онцлогтой.

Улсын хилийн нийгэм-улс төрийн мөн чанар нь уламжлал болсон "социалист-капиталист" гэсэн томъёоллоор ойлгодог туйлширсан хэвшмэл хэв загвараас аль хэдийн халин гарчээ. Улс төрийн тодорхой шинж төлөвөөс /улс төр, нийгмийн тогтолцоо, явуулж буй улс төрийн бодлогын агуулга, улс оронд явагдаж буй нийгэм үндэстэний хоорондын харилцааны хурцдалт, үндэсний эв нэгдэл гэх мэт/ улс үндэстний хил хязгаар түүний хамгаалалт хяналт шалтгаалдаг болж байна.

Улсын хил түүнийг сахин манах үйл ажиллагаа нь хил орчмынхоо эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах, дэлхий нийтийн аж ахуйн үйл ажиллагаанд улс орноороо хамрагдан оролцож эдийн засгаа хөгжүүлэх бололцоо нөхцөлийг хангах үндсэн зориулалттай болов.

Улс хоорондын хил заагийн асуудлаархи дээрхи онолын баримтлалуудыг улам дэлгэрүүлж судлах нь хил судлалын онолыг хөгжүүлэхэд онол арга зүйн хувьд чухал ач холбогдолтой төдийгүй Монгол улсын өнөөгийн тогтоогдсон хил хязгаарыг хэвээр хадгалж хамгаалах онол - арга зүйн үндсийг бүрдүүлэх, хил заагийг шинээр тогтоох, өөрчлөх асуудлаар баримтлах танин мэдэхүйн бааз суурийг өргөсгөх, улсын хил заагийг тогтоосон зарчмын баримтлалын үндэслэлийг бататгахад зохих хувь нэмрээ оруулах болно гэж итгэж байна.

Эрдэм шинжилгээний төвийн дарга,
магистр, дэд хурандаа Ч.Дашдэлэг

